

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

---

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН  
2018 ОНЫ ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТАД  
ХИЙСЭН НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**АУДИТЫН КОД: УАГ-БНАТАГ-2019/НА-02**

БАЯНХОНГОР АЙМГИЙН ОРОН НУТГИЙН  
ХӨГЖЛИЙН САНГИЙН 2018 ОНЫ  
ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТАД  
ХИЙСЭН НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

---

Баянхонгор 2019 он

**Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат**

Утас: 99007576 Цахим хаяг: [munkhbatb@audit.gov.mn](mailto:munkhbatb@audit.gov.mn)

**Аудитын менежер: Д.Цэцэгмаа**

Утас: 88089024 Цахим хаяг: [tsetsegmaadam@audit.gov.mn](mailto:tsetsegmaadam@audit.gov.mn)

**Ахлах аудитор: А.Цээням**

Утас: 99442140 Цахим хаяг: [tseenyama@audit.gov.mn](mailto:tseenyama@audit.gov.mn)

**Аудитор: Ж.Өсөхбаяр**

Утас: 99890393 Цахим хаяг: [usukhbayar\\_j@yahoo.com](mailto:usukhbayar_j@yahoo.com)

---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт  
мэдээллийг дараах хаягаар авна уу.

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

---

**Тайланг хянасан:****Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар****Дарга, тэргүүлэх аудитор****Б.Мөнхбат****Аудитын менежер****Д.Цэцэгмаа****Тайланг бэлтгэсэн:****Ахлах аудитор****А.Цээням****Аудитор****Ж.Өсөхбаяр****2019 оны 04 дүгээр сарын 01****Уг тайланг ҮАГ-ын Цахим хуудаснаас үзнэ үү: [www.audit.mn](http://www.audit.mn)**

Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70442424 дугаарын утас, 70442584 дугаарын факсаар харилцана уу.

**ХАЯГ:**

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар  
Аймгийн ЗДТГ-ын байр,  
Баянхонгор сум,  
Баянхонгор аймаг-  
64000  
Монгол Улс

## АГУУЛГА

Аудитын зорилт, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл	2
Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх	2
Аудитын зорилт	2
Аудитын хамарсан хүрээ	2
Аудитын арга зүй	2
Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт	2
Товчилсон үгийн тайлбар	3
Аудитын дүн	4
Бүлэг 1: Аймгийн ОНХС-гийн эх үүсвэрийг Төсвийн тухай хуулийн 60.2-т заасан эх үүсвэрээр төлөвлөж бүрдүүлсэн ба ОНХС-с 3795.7 сая төгрөгийн санхүүжилт авч сумдад олгох 1541.4 сая төгрөгийн орлогын шилжүүлгийг холбогдох журмын дагуу хуваарилсан байна.	4
Бүлэг 2: ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл, арга хэмжээнд Сангийн сайдын 2016 оны 415 тушаал болон Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд, Сангийн сайдын 2013 оны А-96/71 тоот хамтарсан тушаалаар батлагдсан журмуудыг баримтлалгүй 497.6 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.	5
Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалт, хэрэгжилтийн байдалд хууль журмын дагуу хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.	12
Өмнөх оны аудитаар тогтоогдсон акт, албан шаардлагыг барагдуулсан ч зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.	14
Аудитын дүгнэлт	17
АУДИТЫН ЗӨВЛӨМЖ	18
Тайлан баталгаажуулсан тушаал	20
Байгууллагаас ирүүлсэн санал	21
Хавсралт судалгаа	22



## Аудитын зорилт, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл

**Аудит үндэслэл, эрх** хийсэн бүрэн

Аудитыг Монгол Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны 2019 оны “Аудитын сэдэв батлах тухай” 01 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2019 оны А/03 тоот тушаалаар батлагдсан “Үндэсий аудитын газрын 2019 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-г үндэслэн нэгдсэн удирдамжаар Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

**Аудитын зорилт**

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалт хууль тогтоомжид нийцсэн эсэх, үр дүнтэй хэрэгжсэн эсэхэд аудит хийж, дүгнэлт зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага албан тушаалтанд хүргүүлэх, аудитын тайланг холбогдох байгууллагад танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв.

Дээрх ерөнхий зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэв. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль журамд заасны дагуу төлөвлөж бүрдүүлж хуваарилсан эсэх
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль журамд заасны дагуу төлөвлөж бүрдүүлж, зарцуулсан эсэх
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн төлөвлөлт хэрэгжилтийг журмын дагуу хянаж, тайлагнасан эсэх

**Аудитын хамарсан хүрээ**

Аудитыг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн 2018 оны орлого бүрдүүлэлт, төсөв төлөвлөгөө, хуваарилалт болон хэрэгжүүлсэн хөтөлбөр, төсөл, арга, хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт, тайлагналыг Баянхонгор аймгийн ИТХ, ЗДТГ болон, сумдын ИТХ, ЗДТГ-ыг хамруулан шалгав.

**Аудитын арга зүй**

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, АДБОУС 400, АДБОУС 3000, АДБОУС 4000 дугаар стандартууд, Төрийн хяналт шалгалтын стандарт, Нийцлийн аудитын түр журмыг баримтлан аймаг, сумын ИТХ, ЗДТГ, ХХААГ-ын холбогдох албан тушаалтантай ярилцах, иргэдээс санал асуулга авах, судалгаа авч дүн шинжилгээ хийх, санхүүгийн тайлан, хөрөнгийн данс, анхан шатны баримт, ажлын төлөвлөгөө, тайлантай тулган баталгаажуулах арга зүйг ашиглан аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

**Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт**

Дараах хууль эрхийн актыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав. Үүнд:

Хуулиуд:

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Монгол улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;

Засгийн газрын тогтоол:

- МУ-ын Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоол;

Сангийн сайдын тушаал:

- Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”;
- Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”
- Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”



### Товчилсон үгийн тайлбар

ААН	Аж ахуйн нэгж
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэрлэл
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ИНХ	Иргэдийн нийтийн хурал
НА	Нийцлийн аудит
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ТАГ	Төрийн аудитын газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
УИХ	Улсын их хурал
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХО	Хөрөнгө оруулалт
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс

**АУДИТЫН ДҮН**

**Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл, арга хэмжээний санхүүжилт, гүйцэтгэлд тавих хяналтыг зохих түвшинд хэрэгжүүлээгүйгээс зарим хөрөнгийн үр өгөөж гарахгүй байна.**

***Бүлэг1: Аймгийн ОНХС-гийн эх үүсвэрийг Төсвийн тухай хуулийн 60.2-т заасан эх үүсвэрээр төлөвлөж бүрдүүлсэн ба ОНХНС-с 3795.7 сая төгрөгийн санхүүжилт авч сумдад олгох 1541.4 сая төгрөгийн орлогын шилжүүлгийг холбогдох журмын дагуу хуваарилсан байна.***

1. Төсвийн тухай хуулийн 59.3<sup>1</sup> дахь заалт, Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлал”-ын дагуу Монгол улсын 2018 оны Төсвийн тухай хуулиар ОНХНС-гаас орон нутгийн төсөвт олгох орлогын шилжүүлэг 3795.7 сая төгрөгөөр батлагдсан байна.

2. Аймаг, сумын ОНХС-гийн эх үүсвэрийг ОНХНС-аас 2947.8 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг, олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс авах урамшуулал, дэмжлэгээр 847.9 сая, татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх замаар бий болсон эх үүсвэрээс 60.8 сая, урьд оны үлдэгдэлээс 741.3 сая, орон нутгийн орлогоор 1202.5 сая, өвс тэжээлийн болон малжуулах төслийн эргэн төлөлт, бусад орлогоос 113.1 сая, ЖДҮ-ийг дэмжих зориулалтаар олгосон зээлийн эргэн төлөлтийн орлогоос 100.0 сая, хандив тусламжийн орлогоос 2380.3 сая, нийт 8393.7 сая төгрөгөөр төлөвлөжээ.


3. Тайлант хугацаанд ОНХС-г Төсвийн тухай хуулийн 60.2-т заасан эх үүсвэрээс бүрдүүлсэн ба 2018 оны эхэнд тус сан нь 747.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан бөгөөд ОНХНС-аас 2947.8 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг, олон улсын төсөл, хөтөлбөрөөс 847.9 сая төгрөгийн урамшуулал авч, татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх замаар бий болгосон эх үүсвэрээс 60.8 сая, орон нутгийн төсвөөс 1273.9 сая, хандив, тусламж бусад орлогоор 834.6 сая, нийт 6706.3 сая төгрөгийн орлого төвлөрч, төлөвлөснөөс 1687.3 сая төгрөгийн эх үүсвэр дутуу бүрдүүлсэн байна.

Энэ нь аймгийн ОНХС-д дотоод, гадаадын хандив, тусламжийн орлогоор 2180.0 сая төгрөгөөр төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 319.4 сая төгрөг төвлөрсөнтэй холбоотой байна.

<sup>1</sup> Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас тухайн жил орон нутгийн төсөвт олгох шилжүүлгийг тодорхойлохдоо дараах итгэлцүүрийг үндэслэн тогтооно:



### ОНХС-гийн эх үүсвэр бүрдүүлэлт



4. Аймгийн ИТХ-ын хуралдааны 2017 оны 8/03 тоот тогтоолоор Төсвийн тухай хуулийн 59.2<sup>2</sup> дахь заалт болон Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлал”-ын дагуу сумдад 1541.4 сая төгрөгийг хуваарилж, аймгийн ОНХС-д 2254.3 сая төгрөгийг олгохоор баталсан байна. 2018 онд аймаг, сумдын ОНХС-д олгохоор тооцсон орлогын шилжүүлгийг сум тус бүрээр харуулбал:

Сумдын нэр	Төсвийн тухай хуулийн 59.2.1-д заасан	Төсвийн тухай хуулийн 59.2.2-д заасан	Төсвийн тухай хуулийн 59.2.4-д заасан	Нийт батлагдсан	Сумдын нэр	Төсвийн тухай хуулийн 59.2.1-д заасан	Төсвийн тухай хуулийн 59.2.2-д заасан	Төсвийн тухай хуулийн 59.2.4-д заасан	Нийт батлагдсан
Баацагаан	-	35.2	41.9	77.2	Галуут	-	29.8	35.5	65.3
Баянбулаг	-	22.5	26.8	49.3	Гурванбулаг	-	27.5	32.7	60.2
Баянговь	-	34.1	40.6	74.7	Жаргалант	-	28.1	36.9	65.0
Баянлиг	-	53.6	69.8	123.4	Жинст	-	21.5	25.6	47.0
Баян-Овоо	-	15.8	18.8	34.7	Заг	-	20.5	24.4	45.0
Баян-Өндөр	-	56.3	74.2	130.5	Өлзийт	-	20.6	27.1	47.7
Баянхонгор	-	98.6	117.4	216.0	Хүрээмарал	-	23.3	27.8	51.1
Баянцагаан	-	41.7	49.7	91.4	Шинэжинст	-	51.9	61.8	113.7
Богд	-	26.4	34.6	61.1	Эрдэнэцогт	-	23.7	28.2	51.9
Бөмбөгөр	-	23.7	28.2	51.8	Сумдын дүн	-	693.5	847.9	1,541.4
Бууцагаан	-	38.5	45.9	84.4	Баянхонгор аймаг	636.2	1,618.1	-	2,254.3
НИЙТ ДҮН						636.2	2,311.6	847.9	3,795.7

**Бүлэг 2: ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл, арга хэмжээнд Сангийн сайдын 2016 оны 415 тушаал болон Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд, Сангийн сайдын 2013 оны А-96/71 тоот хамтарсан тушаалаар батлагдсан журмуудыг баримтлалгүй 497.6 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.**

5. Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 4<sup>3</sup> дүгээр зүйлд заасны дагуу аймаг, сумдын ОНХС-

<sup>2</sup> 59.2. Аймаг, нийслэл нь Орон нутгийн хөгжлийн сангаас болон улсын төсвөөс олгосон шилжүүлгийг доор дурдсанаар сум дүүргийн Орон нутгийн хөгжлийн санд хуваарилна.

<sup>3</sup> ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг төлөвлөхөд баримтлах зарчим




ийн хөрөнгөөр 2018 онд 7757.5 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын 256 төсөл, арга хэмжээнд, Төсвийн тухай хуулийн 58.2.12<sup>4</sup>-т заасан мал эмнэлэгийн үйлчилгээний зардалд 517.5 сая, 58.2.15<sup>5</sup>-д заасны дагуу хот тохижилт үйлчилгээний зардалд 118.7 сая, нийт 8393.7 сая төгрөгийг зарцуулахаар баталжээ.

Үүнээс өмнөх оноос шилжиж ирсэн 34 ажилд 1637.3 сая, тухайн онд хэрэгжих 222 төсөл, арга хэмжээнд 6120.2 сая төгрөгийг зарцуулахаар байна.

Аймаг, сумд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөхдөө иргэдээс саналыг авч эрэмбэлэн багийн иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлэн ИТХ-д өргөн мэдүүлж батлуулсан байна.

6. Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр 47 төсөл, арга хэмжээнд 5232.2 сая төгрөгийг зарцуулахаар баталсан нь “Баянхонгор аймгийг 2016-2025 онд хөгжүүлэх хөгжлийн бодлого”-ын баримт бичиг, аймаг, сумдын Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, сумдын хөгжлийн стратеги төлөвлөгөө, хөгжлийн бодлогын баримт бичиг, Баянхонгор аймгийн нийгэм, эдийн засгийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлтэй уялдсан байна.

### Санал асуулга



<sup>4</sup> 58.2.12.мал, амьтны халдварт, шимэгчтэх өвчинтэй тэмцэх, хортон шавжийн устгал, хяналт, гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн хор хохирлыг арилгах, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх;


<sup>5</sup> 58.2.15.аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд хийгдэх том хэмжээний тохижилт, нийтийн эзэмшлийн аж ахуйн үйлчилгээ, нийтийн ариун цэвэр, гудамж талбайн гэрэлтүүлэг, цэвэрлэгээ, хог зайлуулалтыг зохион байгуулах;



Аудитын явцад иргэдээс авсан санал асуулгын дүн болон иргэдээс “ОНХС-ийн хэлэлцүүлгийг зохион байгуулахдаа ард иргэддээ мэдээллийг илүү хүртээмжтэй хүргэж байх” гэсэн саналыг өгч байгаагаас үзэхэд Төрөөс иргэдэд мэдээлэл хүргэх байдал нь сайжирсан боловч иргэдийн саналаа өгөх, хэлэлцүүлэгт оролцох байдал нь сул байгаа тул иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай байна.

7. 2018 онд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлаас ТБОНӨХБАҮХАТХ-ийн 7.1<sup>6</sup>-д заасны дагуу 21 ажлыг нээлттэй тендер шалгаруулалтаар, 44 ажлыг харьцуулалтын аргаар худалдан авах ажиллагаа зохион байгуулж, 148 ажилд шууд гэрээ байгуулсан бол 9 ажил хэрэгжээгүй байна.

2018 онд шинээр хэрэгжүүлэхээр батлагдсан ТАХ



Харин аймгийн хэмжээнд 2018 онд өмнөх оноос шилжиж ирсэн болон шинээр батлагдсан нийт 256 төсөл, арга хэмжээнээс 1425.9 сая төгрөгийн 31 ажил огт хэрэгжээгүй ба гэрээ байгуулсан 225 ажлаас 3701.6 сая төгрөгийн 190 ажил бүрэн хэрэгжиж, 2458.2 сая төгрөгийн 35 ажил дутуу хэрэгжсэн байна.

#### **Аудитын илрүүлэлт:**

➤ Засгийн газрын тогтоолоор баталсан босго үнээс дээш үнийн дүн бүхий Бөмбөгөр сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих 25.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий өвс, хадлан бэлтгэх ажлыг шууд гэрээ байгуулж хэрэгжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 24.4<sup>7</sup>, дэх заалтыг зөрчсөн тул цаашид алдааг давтан гаргахгүй байх зөвлөмжийг хүргүүлэв.

8. 2018 онд ОНХС-ийн хөрөнгөөр төсөл, хөтөлбөр, арга хэмжээнд 5771.4 сая төгрөгийг зарцуулж, оны эцэст аймаг, сумдын ОНХС-ийн харилцах данс нь 2018

<sup>6</sup> 7.1.Захиалагч бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа дор дурдсан тендер шалгаруулалтын журмыг баримтлан гүйцэтгэчийг сонгож гэрээ байгуулна:

<sup>7</sup> 24.4.Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно.



оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 962.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

№	Сум	сая. төг					
		Эхний үлдэгдэл	Авсан санхүүжилт	Бусад орлого	Нийт орлогын дүн	Нийт зарлагын дүн	Эцсийн үлдэгдэл
1	Баацагаан	48.0	77.2	56.9	134.1	84.0	98.1
2	Баянбулаг	33.8	49.3	-	49.3	45.0	38.1
3	Баянговь	22.9	74.7	20.3	95.0	87.9	29.9
4	Баянлиг	50.8	123.4	4.2	127.6	109.3	69.2
5	Баян-Овоо	1.0	34.7	87.0	121.7	117.6	5.0
6	Баян-Өндөр	6.3	130.5	-	130.5	73.9	63.0
7	Баянхонгор сум	28.1	216.0	19.2	235.2	171.1	92.3
8	Баянцагаан	30.3	91.4	5.5	96.9	110.2	17.0
9	Богд	41.0	61.1	2.6	63.7	62.1	42.6
10	Бөмбөгөр	120.4	51.8	23.1	74.9	195.3	0.0
11	Бууцагаан	94.9	84.4	65.2	149.6	127.9	116.5
12	Галуут	54.1	65.3	45.2	110.5	93.7	70.9
13	Гурванбулаг	5.1	60.2	6.0	66.2	53.2	18.0
14	Жаргалант	50.2	65.0	9.0	74.0	82.3	41.9
15	Жинст	5.1	47.0	12.3	59.4	50.3	14.2
16	Заг	94.5	45.0	7.7	52.7	85.3	61.9
17	Өлзийт	7.7	47.7	36.8	84.5	45.4	46.9
18	Хүрээмарал	3.8	51.1	0.6	51.7	53.8	1.7
19	Шинэжинст	4.4	113.7	39.2	152.9	141.2	16.2
20	Эрдэнэцогт	41.7	51.9	31.7	83.6	28.1	97.1
Сумдын дүн		744.2	1,541.4	472.5	2,013.8	1,817.5	940.5
21	Аймгийн ОНХС	3.2	1,618.1	1,718.1	3,336.2	3,317.7	21.7
	Мал эмнэлэгийн үйлчилгээний зардалд		517.5		517.5	517.5	-
	Хот тохижилт үйлчилгээний зардалд		118.7		118.7	118.7	-
Аймгийн дүн		3.2	2,254.3	1,718.1	3,972.4	3,953.9	21.7
Аймгийн нийт дүн		747.4	3,795.7	2,190.5	5,986.2	5,771.4	962.3

9. Сумдын өмнөх оны ОНХС-д хийсэн нийцлийн аудитаар зориулалт бусаар зарцуулсан зөрчил илэрсэнд зөвлөмж өгсөн байхад 2018 онд ОНХС-гийн 20.8 сая төгрөгийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан, гэрээний үүргийн биелэлтэд тавих хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй, ажлын гүйцэтгэлээр санхүүжилтийг олгоогүйгээс 62.9 сая төгрөгийн төсөл, арга хэмжээ гэрээний дагуу хэрэгжээгүй зэрэг зөрчил илэрлээ.

#### **Аудитын илрүүлэлт:**

➤ Галуут, Баянбулаг сумд төрийн захиргааны төсөвт байгууллагын урсгал зардал болон хувийн хэвшлийн хөрөнгийн зардалд 24.8 сая төгрөгийг баталж 20.8 сая төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 60.3.1<sup>8</sup> дэх заалтыг зөрчсөн тул цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмжийг хүргүүлэв.

➤ Бууцагаан сумын 6-р багийн цэцэрлэгт хүрээлэнгийн ногоон байгууламжийг нэмэгдүүлж мод, бут тарих ажлын захиалагчийн хяналтын зардал, магадалшгүй ажлын зардал 0.2 сая төгрөгийн зардлыг суутгаан тооцоогүй гүйцэтгэгчид илүү ишлүүлсэн тул төлбөрийн акт тогтоов.

<sup>8</sup> 60.3.1.орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргээс бусад хөтөлбөр, арга хэмжээ.



Төсөл арга хэмжээний нэр	ИТХ-с батлагдсан дүн	Гэрээний дүн	Хүснэгт: Зориулалт бусаар зарцуулсан хөрөнгийн жагсаалт
			сая төгрөгөөр 2018 онд олгосон санхүүжилт
Цагдаагийн торгуулын машин /Баянбулаг/	2.3	2.3	2.3
Мандал багт "Хүрээ гудамж" төсөл хэрэгжүүлэх /Галуут/	20.0	20.0	16.0
Цагдаагийн торгуулийн бэлэн бус машин худалдан авах /Галуут/	2.5	2.5	2.5
НИЙТ	24.8	24.8	20.8

**Аудитын илрүүлэлт**

➤ Баянхонгор сумын ОНХС-ийн хөрөнгөөр Төсвийн тухай хуулийн 29.4<sup>9</sup> дэх заалт, Барилгын тухай хуулийн 22<sup>10</sup> дугаар зүйлийг зөрчин Сити-00 барих ажлыг 79.6 сая төгрөгийн өртөг бүхий гэрээг “Жаргантайн хөх тариа” ХХК-тай байгуулан 2018 онд 54.9 сая төгрөгийн санхүүжилт олгосон мөн Баянхонгор сумын нийтийн эзэмшлийн талбайд хогийн сав нийлүүлэх ажлыг “Сайн үйлс баян” хоршоотой 8.5 сая төгрөгийн гэрээ байгуулан 8.0 сая төгрөгийг тус тус олгосон боловч гүйцэтгэгч нар гэрээний үүргээ биелүүлээгүй гэрээт хугацаандаа ажлыг хүлээлгэн өгөөгүй байгаа тул гэрээний үнийн дүнд алданги тооцон төсөвт төлүүлэн, гэрээний үүргийг хангуулах албан шаардлагыг Баянхонгор сумын Засаг даргад хүргүүлэв.

10. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 150.7 сая төгрөгийн 19 төсөл арга хэмжээний зураг төсөв, инженер геологийн судалгааны ажлын санхүүжилт олгосноос 14.9 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

**Аудитын илрүүлэлт**

➤ Аймгийн МХГ-ын лабораторийн барилгын зураг төсвийн үнэнд “Орд дизайн” ХХК-д 5.0 сая, аймгийн Цагдаагийн газрын албан бэлтгэлийн танхимын зураг төсвийн үнэнд “ЦЭСДА” ЗБН-д 9.9 сая төгрөгийг шилжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 60.3.1 дэх заалт, Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 7.2.1а<sup>11</sup> дэх заалтыг зөрчсөн тул цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэв.

11. Баянхонгор аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 3317.7 сая төгрөгийг зарцуулснаас гэрээний хэрэгжилтэд хяналтыг тавиагүй ажлын гүйцэтгэлээр санхүүжилтийг олгоогүйгээс 398.8 сая төгрөгийн зөрчил илэрлээ.

**Аудитын илрүүлэлт**

➤ “Ган мөнхжин” ХХК 450,6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий Угалз 4-р багт спорт заал бүхий багийн хөгжлийн төв барих тендерт шалгарч, ажлыг 2017.08.11-2017.11.15-ны өдөр дуусгахаар 2017.08.11-ны өдөр гэрээ байгуулж, 2017 онд 170.0 сая, 2018 оны 5 сард 100,0 сая, 7-р сард 50,0 сая, нийт 320,0 сая төгрөгийг буюу нийт төсөвт өртөгийн 71.0 хувийн санхүүжилтийг авсан байна.

Баянхонгор аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ болон гүйцэтгэгч компанийн ирүүлсэн тодорхойлолтоор ажлын гүйцэтгэл 70 хувьтай байна гэж ирүүлсэн бөгөөд ажлын гүйцэтгэлийг газар дээр нь шалгахад санхүүжилт авсан хэмжээнд ажлыг гүйцэтгээгүй, багийн төвийн барилгын дотор, гаднах засал, сантехникийн ажил хийгдээгүй, спорт заалны барилгын гадна карказ босгосноос бусад ажил хийгдээгүй, барилгын ажил удаашралтай, ажил гүйцэтгэх гэрээг сунгаагүй байгаа тул цаашид 2019.06.15-ны дотор авсан санхүүжилтийн хэмжээнд дутуу ажлыг гүйцэтгүүлж, үлдэгдэл ажлыг 2019.09.01-ний дотор гүйцэтгүүлэн хүлээн авах албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

➤ Баянхонгор сумын гэр хороололд агаар, хөрсний бохирдлоос сэргийлсэн стандарт 00-ийг 4, 5 дугаар багийн 35 өрхийн хашаанд 2018.10.08-наас 2018.11.09-ны хугацаанд гүйцэтгүүлэхээр “Бага шаргалжуут” ХХК-тай 2018.10.05-ны өдөр БХ-2018/АГ-10 тоот гэрээ байгуулж, урьдчилгаа санхүүжилтэд 21,0 сая төгрөгийг 2018.10.31-нд олгосон байна.

Гүйцэтгэгч нь 4-р багийн 11 дүгээр гудамжинд 14 айлын стандарт ОО-н нүх ухаж блокоор өрлөг хийж доторлосон, 27ш төмөр рамыг угсарч бэлтгэж, холбогдох хавтан, цемент

<sup>9</sup> 29.4.Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

<sup>10</sup> 22 дугаар зүйл. Техникийн нөхцөл олгох

<sup>11</sup> 7.2.1а. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын зураг төсөв, ТЭЗҮ боловсруулах



зэрэг материалуудыг татсан ч хүйтний улирал эхэлснээс ажил зогсож гүйцэтгээгүй байгаа тул 2019.06.15-ны дотор гэрээний үүргийг хангуулах албан шаардлагыг хүргүүллээ.

➤ Баянхонгор сумын 2, 3 дугаар багийн гэр хороололд спортын талбай, цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажлын тендерт “Хүрэнжинсний овоо” ХХК, “Эх өлзийт богд” ХХК оролцсоноос “Эх өлзийт богд” ХХК-ийн ирүүлсэн тендерийг шалгаруулж, шалгарсан компанитай гэрээ байгуулах зөвлөмжийг Үнэлгээний хороо 2018.06.18-ны өдрийн 16/133 тоотоор хүргүүлсэн байна.

Аймгийн Засаг дарга Баянхонгор сумын 2, 3 дугаар багийн гэр хороололд спортын талбай, цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажлыг 116,7 сая төгрөгөөр, 2018.06.28-2018.08.20-ны өдөр ашиглалтад өгөх гэрээг “Эх өлзийт богд” ХХК-ийн захиралтай байгуулж, 2018 онд 100,0 сая, 2019 онд 16,7 сая төгрөгийг олгохоор гэрээнд тусгасан байна. 2018.08.20-ны өдөр нэмэлт гэрээ байгуулан 2018.11.25-ны өдөр ашиглалтад оруулахаар гэрээ сунгаж, ажлын санхүүжилтэд 2018.07.04-нд 35,0 сая, 2018.11.02-нд 40,0 сая, 2018.12.05-нд 18,2 сая төгрөгийг гүйцэтгэгчид олгож, хяналтын зардал, нормчлолын сангийн зардалд 6,8 сая төгрөгийг шилжүүлсэн байна.

Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ээс ирүүлснээр ажлын явц гүйцэтгэлээр 90%-тай, суурийн болон хайс, хашаажуулалтын ажлыг хийж дуусгасан ба шаардагдах тоног төхөөрөмж тоглоомыг авчирсан боловч угсарч суулгаж амжилгүй хүйтэрсэн тул, гэрээний хугацааг 2019.05.30-ны өдөр хүртэл сунгасан гэсэн тайлбар ирүүлсэн.

Ажлын гүйцэтгэлийг газар дээр нь шалгахад хайс, хашаажуулалтын ажил хийгдсэн бусад ажил хийгдээгүй байна. Иймд дутуу ажлыг 2019 оны 05 дугаар сарын 20-ны дотор гүйцэтгүүлэх албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

➤ Хаш өргөө ХХК нь Тээврийн товчооны үйлчилгээний газруудыг цэвэр бохирын шугаманд холбох ажлыг гүйцэтгэгчээр шалгарч 2018 онд 37,8 сая төгрөгийн ажлыг гүйцэтгэн 2018.08.29-ны өдөр ашиглалтанд хүлээлгэн өгсөн байна.

Ажлын гүйцэтгэлтэй танилцаж зарим хэрэглэгчтэй ярилцлага хийх явцад тухайн цэвэр усны шугам болон өмнөх оны ОНХС-ийн хөрөнгөөр хийсэн бохирын шугаманд нэг хэрэглэгч холбогдсон бөгөөд 2018 оны 12-р сард шугам хөлдсөнөөс хэрэглээ зогссон байдалтай байгаагаас үзэхэд, уг хөрөнгө оруулалтаас гарах эрсдэлийг урьдчилан тооцоогүйгээс хөрөнгө оруулалтын үр өгөөж, үр дүн гараагүй байгаа тул баталгаат засварын хугацаанд гүйцэтгэгчээр засвар үйлчилгээг хийлгэж хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх албан шаардлагыг хүргүүлэв.

➤ Баянхонгор-Өлзийт чиглэлийн замын дагуу мод тарих, Баянхонгор сумын ойн зурвасын хамгаалалтыг сайжруулах, аймгийн төвийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх 3 багц ажилд 150,0 сая төгрөг батлагдснаас 2 дугаар багцын 50,0 сая төгрөгийн ажлыг гүйцэтгэхээр “Баяншар булаг” ХХК, 1, 3 дугаар багцын 100.0 сая төгрөгийн ажлыг “Хонгорын шугуй” ХХК-иар гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсан байна.

“Хонгорын шугуй” ХХК-д урьдчилгаа санхүүжилт 50 хувь олгохоор заасны дагуу 2018.08.24-нд 35,0 сая, 2018.09.27-нд 15.0 сая төгрөгийг олгож, 2018.11.20-нд Өлзийт сумын зам дагуух 3 км газар мод тарьсан ажлын гүйцэтгэлийн тайланг ирүүлсэн ба уг тайланд 2019 оны хавар тариалах суулгацыг бэлтгэсэн, бусад гарсан зардлын тооцоог хийж 45,0 сая төгрөг нэхэмжилснийг үндэслэн 2018.12.19-нд 40,0 сая төгрөгийг олгосон нь Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд, Сангийн сайдын 2013 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн А-96/71 тоот хамтарсан тушаалаар батлагдсан “Ойжуулалт ойн арга хэмжээний ажлыг төлөвлөх, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын санд худалдан авах, өмчлүүлэх журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.5.2<sup>12</sup> дэх заалтыг зөрчсөн байна.

Баянхонгор-Өлзийт чиглэлийн замын дагуу ойн зурвас байгуулах 50.0 сая төгрөгийн ажлын техникийн тодорхойлолтод 3 км газарт 2 м өндөртэй 3-4 настай модыг 5 эгнээгээр, мод хооронд 2 метрийн зайтай 8000 ширхэгээс доошгүй навчит мод /цагаан бургас, улиас/ тарьж ургуулж, 3 жилийн хугацаанд арчлал хамгаалалтыг хийж 2018-2020 онд хүлээлгэн өгөхөөр заасан, дээрх талбайд тус компани нь ОНХС-с 2017 онд 62.6 сая төгрөгийн ойн зурвас байгуулах ажил гүйцэтгэхээр урьдчилгаа санхүүжилтэд 50.0 сая төгрөг авсан байна.

Тус компани нь аймгийн төвийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх 50,0 сая төгрөгийн ажлыг жишиг гудамж дагуу техникийн тодорхойлолтод тусгаснаар 1230 м<sup>2</sup> талбайд 2 эгнээгээр 25 см алслалттай 6500 –аас доошгүй 1 м-ээс дээш өндөртэй 2-4 настай, орон нутагт тарьж ургуулсан шар хуйс, хайлаас тариалах ажлыг гүйцэтгэн, эхний жил ажлаа бүрэн хийж дараагийн жилүүдэд ургалт, арчлал хамгаалалтыг хийж 2018-2020 онд хүлээлгэн өгөхөөр гэрээг байгуулсан нь дээрх журмын 5.9.2 заасан жишиг нормативыг мөрдөөгүй байна.

<sup>12</sup> 4.5.2 Төсөвт зардлын үлдсэн төлбөрийг аймаг, нийслэлийн Засаг даргын томилсон ажлын хэсгийн гаргасан актыг үндэслэн тарьсан тарьц суулгацын амьдралт 75 хувиас дээш байвал олгоно



Аудитаар Байгаль орчны газрын мэргэжилтнүүдтэй хамтран суулгацын тоог тоолж үзэхэд 1234 ш суулгац тоологдсон нь гэрээнд зааснаас 5266 мод дутуу байна.

Иймд техникийн тодорхойлолтод заагдсан ажлууд бүрэн хийгдээгүй байгаа тул мэргэжлийн байгууллагаас бүрдсэн ажлын хэсэг томилон 2017, 2018 онуудад санхүүжилтээр авсан 140.0 сая төгрөгийн ажлуудыг нэг бүрчлэн хэмжиж, тоолон шалгуулж дүгнэлт гаргуулан, үр дүнг тооцож ирүүлэх албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

➤ Аймгийн аюулгүй нөөцийн газрын ард талд нөөцийн хашаа барих ажлын гүйцэтгээчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хороог аймгийн Засаг даргын 2018.05.08-ны а/362 тоот захирамжаар байгуулж, тендерт гүйцэтгэгчээр “Эх өлзийт бөгд” ХХК шалгарч, ажлыг 44124,9 мянган төгрөгөөр гүйцэтгэн санхүүжилтийг бүрэн авсан байна. Ажлын гүйцэтгэлийг шалгахад блокон хашаа нь төсөвт тусгасан хэмжээнээс 11.4 метрээр бага буюу 1.2 сая төгрөгийн ажил дутуу хийгдсэн байгаа тул төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

12. 2018 онд ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар санхүүжсэн 5135.1 төгрөгийн төсөл, арга хэмжээнээс 310.5 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэл тайланд тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4<sup>13</sup>, Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам” 6.1, “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 8.6<sup>14</sup> дахь заалтыг зөрчсөн байна.

**Аудитын илрүүлэлт:**

➤ 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар Бөмбөгөр сум Тариалан эрхлэлтийн дэмжих сангаас 84.4 сая төгрөгийн газар тариалангийн тоног төхөөрөмж худалдан авч 2018 онд 42.0 сая төгрөг шилжүүлж үлдэгдэл төлбөрийг 2024 он хүртэл хувааж төлөхөөр гэрээ байгуулсан ч өглөгөөр тусгаагүй, Бууцагаан сум “ЦЭСДА” ХХК-д олгосон халуун усны барилгын зураг төсвийн үнэ болох 3.1 сая төгрөгийг, Эрдэнэцогт сум “Ган хошуу” ХХК-д төлсөн ЗДТГ, ЕБС, Соёлын төвийн инженер геологийн судалгааны ажлын хөлсийг авлагаар тусгаагүй байсныг санхүүгийн тайланд залруулж тусгуулсан байна.

Харин Заг сум Соёлын төв, сургуулийн өргөтгөл, халуун усны барилгын инженер, геологийн дүгнэлтийн төлбөрт 3.0 сая төгрөг шилжүүлсэн ч санхүүгийн тайланд авлагаар тусгаж баталгаажуулаагүй байгаа тул 2019 оны 01 дүгээр улирлын санхүүгийн тайланд авлагаар тусгах албан шаардлага хүргүүлэв.

➤ Сумд 2013 оноос хойш ОНХС-ийн хөрөнгөөр малжуулах арга хэмжээнд 685.1 сая төгрөгийн зарцуулснаас 307.5 сая төгрөгийг бүртгэлд тайланд тусгаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.2<sup>15</sup> дэх заалтыг зөрчиж байгаа тул тус арга хэмжээнд зарцуулсан санхүүжилтийг 2019 оны 01 дүгээр улирлын санхүүгийн тайланд тусгах албан шаардлагыг хүргүүлж цаашид хэрэгжилтийг сумын ИТХ-р хэлэлцүүлж үр дүнг тооцож, үр ашгийг дээшлүүлэх талаар шийдвэр гаргуулж ажиллах зөвлөмжийг сумдын Засаг дарга нарт хүргүүлэв.

Хүснэгт: Малжуулах арга хэмжээнд олгоод бүртгэл тайланд тусгаагүй санхүүжилт

Сумын нэр	Олгосон						Бүртгэл тайланд тусгаагүй дүн
	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он	
Галуут сум	60.0						60.0
Баян-Өндөр сум	60.0						60.0
Шинэжинст сум	35.0						35.0
Баян-Овоо сум		8.0					8.0
Гурванбулаг сум	63.0		14.0	30.0		22.0	107.0
Баянговь сум	37.5						37.5
НИЙТ	255.5	8.0	14.0	30.0	-	22.0	307.5

➤ Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн “Шинэ суурьшилийн бүсийн хэсэгчилсэн төлөвлөгөө хийлгэх” ажилд олгосон 33.1 сая төгрөгийн олгосон санхүүжилтийг санхүүгийн

<sup>13</sup> 13.4.Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна.

<sup>14</sup> 8.6. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтыг орон нутгийн өмчид бүртгэнэ.

<sup>15</sup> 14.4.2.бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага;



тайланд тусгаагүй байсныг аудитын явцад Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд тусгаж залруулав.

➤ Аймгийн ОНХС-гаас ТЭЗҮ, зураг төсөв хийлгэх ажлын санхүүжилтэд 150.7 сая төгрөгийг олгосон ч санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй, 2017 оны ОНХС-с олгосон зураг төсвийн үнээс суутгаагүй үлдэгдэл 120.0 сая төгрөгийг бүртгэлд тусгаагүй байсныг аудитын явцад Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд тусгуулж залруулав.

### **Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалт, хэрэгжилтийн байдалд хууль, журмын дагуу хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.**


13. Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 9.1<sup>16</sup>, Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.4<sup>17</sup>-т заасны дагуу сумдын ИТХ-ын дэргэд хяналтын хороо байгуулагдан иргэд, олон нийтийн оролцоотой хяналт хэрэгжүүлэн ажиллаж байна.

Харин Сангийн яамнаас олон улсын байгууллагын санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Тогтвортой амьжиргаа-3” төслийн хүрээнд сумдын ОНХС-ын хөрөнгийн төлөвлөлт, гүйцэтгэлд хийсэн жилийн гүйцэтгэлийн үнэлгээгээр Өлзийт, Хүрээмарал, Баян-Өндөр, Гурванбулаг, Бууцагаан сумдын ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжиж буй хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд сумын ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо, иргэд, иргэний нийгмийн байгууллагуудаас хяналт-шинжилгээ хийгээгүй гэж үнэлэгдсэн байна.


Тус үнэлгээгээр сумдын дундаж үнэлгээ 2016, 2017 онд 29.5 хувьтай байсан бол 2018 онд ОНХС-гийн үйл ажиллагааны үр дүн сайжирч 50 хувийн дундаж үнэлгээтэй болж улсын дундаж үзүүлэлттэй ижил түвшинд очсон, сумдаас хамгийн өндөр 68-78 хувийн үнэлгээгээр Хүрээмарал, Эрдэнэцогт сум, хамгийн бага 41-43 хувийн үнэлгээгээр Жинст, Баянговь, Бууцагаан, Галуут сумд үнэлэгдсэн байна.

<sup>16</sup> 9.1.ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт санхүүжилт, гүйцэтгэлийн явцад хяналт шалгалтын байгууллагууд, тухайн орон нутгийн ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд хяналт тавьж ажиллана.

<sup>17</sup> 9.4.ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэл болон энэ журмын хэрэгжилтэд төв, орон нутгийн хууль, хяналт, дотоод ба хөндлөнгийн аудитын байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын дэргэдэх хороо болон иргэд, иргэний нийгмийн байгууллагууд Монгол Улсын Төрийн аудитын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2015 оны “Дүрэм батлах тухай” 483 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Дотоод аудитын дүрэм” болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжид заасан чиг үүргийн дагуу хяналт тавина.



Мөн аудитын явцад 484 иргэнээс ОНХС-гийн үйл ажиллагааны талаар санал асуулга авахад 205 иргэн орон нутгийн сангийн үйл ажиллагааны талаар мэдээлэл муу, 281 иргэн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээнд хяналт тавьж оролцдоггүй гэсэн хариулт өгсөн нь иргэдийн идэвхи, оролцоо хангалттай бус байгааг харуулж байна.



Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт аудитын алба нь 2018 оны ОНХС-гийн төлөвлөлт, гүйцэтгэл, зарцуулалтад хяналт, шалгалтыг 2019 оны 5 дугаар сард хийхээр төлөвлөсөн байна.

14. Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.2<sup>18</sup>-д заасны дагуу 2018 онд ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга

<sup>18</sup> 9.2.Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг гаргаж дараа оны 2 дугаар сарын 01-ний өдрийн дотор аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст хүргүүлэх ба энэ журмын 9.9- д заасан мэдээллийг багтаана.



хэмжээний хэрэгжилтийн тайланг сумд аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-т журамд заасан хугацаанд ирүүлсэн байна.

Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ нь дээрх журмын 9 дүгээр зүйлийн 9.9<sup>19</sup>-д заасны дагуу сумдын 2018 оны ОНХС-ийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг нэгтгэж журамд заасан хугацаанд Сангийн яаманд хүргүүлсэн байна.

Харин журмын 9.3<sup>20</sup>-д заасны дагуу ХОХБТХ нь ОНХС-ийн хэрэгжилтийн тайланг сум тус бүрээр гарган, дүгнэлт өгч, авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний саналыг боловсруулан аймгийн Засаг даргад танилцуулж, холбогдох асуудлаар тодорхой шийдвэрийг гаргуулж ажиллаагүй байх тул цаашид журамд заасны дагуу санал дүгнэлт гарган тодорхой шийдвэрийг гаргуулж ажиллах зөвлөмжийг хүргүүлэв.

15. Аймаг, сумын ОНХС-гийн төсвийн захирагч нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй ба хуулийн 6.1.1<sup>21</sup>, 6.3.9<sup>22</sup>-д заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд нь мэдээлж хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

### **Өмнөх оны аудитаар тогтоогдсон акт, албан шаардлагыг барагдуулсан ч зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.**

16. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 2017 оны төлөвлөлт, бүрдүүлэлт, зарцуулалтад хийсэн нийцлийн аудитаар аймгийн ИТХ-ын даргад 1, аймгийн Засаг даргад 3, орон нутгийн өмчийн газрын даргад 1, аймгийн ХХААГ-ын даргад 1, сумын ИТХ-ын дарга, Засаг дарга нарт 4, нийт 10 зөвлөмж өгсөн бөгөөд зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаж байгаа гэсэн хариу ирүүлсэн боловч Бөмбөгөр сум Засгийн газрын тогтоолоор баталсан босго үнээс буюу 25.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий өвс, хадлан тариа бэлтгэх ажлыг шууд гэрээ байгуулж хэрэгжүүлсэн, аймгийн ИТХ-ын дэргэдэх хяналтын хороо нь ОНХС-гийн үйл ажиллагаанд хяналтыг бүрэн хэрэгжүүлж тайланг ИТХ-аар хэлэлцээгүй, мөн ОНХС-аас олгосон зураг төсвийн үнийг санхүүгийн тайланд авлагаар тусгах 139.4

<sup>19</sup> 9.9.Аймаг, нийслэлийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХС-ийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг нэгтгэж, жил бүрийн 3 дугаар сарын 10-ны өдрийн дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ОНХС-ийн асуудал хариуцсан хэлтэст ирүүлэх бөгөөд тайланд дараах мэдээллийг багтаана.

<sup>20</sup> 9.3.Аймаг, нийслэлийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь ОНХС-ийн хэрэгжилтийн тайланг сум, дүүрэг тус бүрээр хагас жил тутамд гарган, дүгнэлт өгч, цаашид даруй авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний саналыг боловсруулан аймаг, нийслэлийн Засаг даргад танилцуулж, холбогдох асуудлаар тодорхой шийдвэрийг гаргуулна.

<sup>21</sup> 6.1.1.тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор;

<sup>22</sup> 6.3.9.орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэл.



сая төгрөгийн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байгаагаас үзэхэд өмнөх оны зөвлөмжөөс 3 заалт бүрэн хэрэгжээгүй байна.


Мөн ОНХС-ийн 2017 оны жилийн эцсийн СТА-р 10 суманд бүртгэл тайлагналтай холбоотой 2, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 10, бусад төрлийн 1, нийт 13 зөвлөмж өгснийг хэрэгжүүлсэн байна.

Аймгийн ОНХС-ийн 2017 оны төлөвлөлт, бүрдүүлэлт, зарцуулалтад хийсэн нийцлийн аудитаар 2.3 сая төгрөгийн төлбөрийн акт, 527.7 сая төгрөгийн зөрчил арилгах албан шаардлага өгснийг биелүүлж ажиллажээ.

Аймаг, сумдын ОНХСангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн СТА-р 12,2 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 26,1 сая төгрөгийн албан шаардлагыг хэрэгжүүлсэн байна.

Аудитаар нийт 884.5 сая төгрөгийн төлбөр, зөрчил илрүүлж 1.3 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 822.2 сая төгрөгийн зөрчил арилгах хугацаатай албан шаардлага, 61.0 сая төгрөгийн зөвлөмж хүргүүлэв.

### Шалгагдагч байгууллагын санал:

 <b>МОНГОЛ УЛС</b> <b>БАЯНХОНГОР АЙМГИЙН</b> <b>ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР</b> 64101 Номгон, Баянхонгор сум Вэбсайт: www.bayankhongor.gov.mn Утас/Факс: (976) 70-44-22-73	<b>БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ</b> <b>ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ</b>
2019.04.08 № 1/СТА танай _____ -ны № _____ -т Санал хүргүүлэх тухай	
Орон нутгийн хөгжлийн сангийн 2018 оны хөрөнгийн зарцуулалтад хийсэн нийцлийн аудитын тайланг уншиж танилцаад дараахь ажлуудыг хасуулах саналтай байна. Үүнд:	
<b>САНАЛ-1</b>	1.Аймгийн ОНХСангийн ТЭЗҮ-д тусгагдсан 2017-2018 онд зарцуулсан 270,7 сая төгрөгийг авлага үүсгэн бүртгэлд авсан.
<b>САНАЛ-2</b>	2.Баянговь сум 2018 оны ОНХСангийн жилийн хэрэгжилтийн тайлангаа файлаар Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст хүргүүлсэн.
 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГА  Д.ИХБАЯР	

**Саналд өгсөн тайлбар:**

Тайлбарын дугаар	Саналыг хүлээн авсан эсэх	Тайлбар
Тайлбар №1	Тийм	Аймгийн ОНХС-гаас ТЭЗҮ, зураг төсөв хийлгэх ажлын санхүүжилтэд 150.7 сая төгрөгийг олгосон ч санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй, 2017 оны ОНХС-с олгосон зураг төсвийн үнээс суутгаагүй үлдэгдэл 120.0 сая төгрөгийг бүртгэлд тусгаагүй байсныг аудитын явцад Баянхонгор аймгийн ТЭЗ-ийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд тусгуулж залруулж албан шаардлага өгөөгүй.
Тайлбар №2	Тийм	Сумд аудитын явцад тайлангаа ирүүлж ХОХБТХ нь журмын 9 дүгээр зүйлийн 9.9 -д заасны дагуу сумдын 2018 оны ОНХС-ийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг нэгтгэж журамд заасан хугацаанд Сангийн яаманд хүргүүлсэн байгаа тул зөвлөмжөөс хассан болно.



## АУДИТЫН ДҮГНЭЛТ

Нийцлийн аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг өгч байна. Үүнд:

1. Аймгийн ОНХС-гийн эх үүсвэрийг Төсвийн тухай хуулийн 60.2-т заасан эх үүсвэрээр төлөвлөж бүрдүүлсэн ба ОНХНС-с 3795.7 сая төгрөгийн санхүүжилт авч сумдад олгох 1541.4 сая төгрөгийн орлогын шилжүүлгийг холбогдох журмын дагуу хуваарилсан байна.

2. Санал асуулгын дүнгээс үзэхэд төрөөс иргэдэд мэдээлэл хүргэх байдал нь сайжирсан боловч иргэдийн саналаа өгөх, хэлэлцүүлэгт оролцох идэвхи, оролцоо хангалтгүй байна.

3. Аймгийн ОНХС-ийн эх үүсвэрт хандив тусламжийн орлогоор 2180.0 сая төгрөг оруулахаар өмнөх оны гүйцэтгэлд суурилж, тооцоо судалгаагүйгээр баталснаас гүйцэтгэлээр 319.4 сая төгрөг орж сангийн төлөвлөсөн ажлуудыг бүрэн хэрэгжүүлэх боломжгүй болсон байна.

4. Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг олгохдоо ажлын гүйцэтгэл, гэрээний нөхцлийг үндэслэж Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт тайлагналын журам”-ыг мөрдөж ажиллахгүй байгаа нь өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүйтэй холбоотой байна.

5. Ойжуулалт, ойн зурвас, ногоон байгууламж бий болгох, булаг шандын эхийг хашах зэрэг төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа техникийн тодорхойлолтыг мэргэжлийн байгууллагаар гаргуулаагүй, гэрээний дагуу хэрэгжүүлтэд үе шатны хяналт тавиагүй, үр дүнг үнэлээгүй байна.

6. Дээрх арга хэмжээний санхүүжилтийг олгохдоо Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд, Сангийн сайдын 2013 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн А-96/71 тоот хамтарсан тушаалаар батлагдсан “Ойжуулалт ойн арга хэмжээний ажлыг төлөвлөх, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын санд худалдан авах, өмчлүүлэх журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.5.2 дахь заалтыг мөрдөөгүй байна.

7. ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжсэн 310.5 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэл тайланд тусгаагүй байна.

8. Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ нь ОНХС-ийн хэрэгжилтийн тайланг сум тус бүрээр гарган, дүгнэлт өгч, цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний саналыг боловсруулан аймгийн Засаг даргад танилцуулж, холбогдох асуудлаар тодорхой шийдвэрийг гаргуулж ажиллаагүй байна.

**АУДИТЫН ЗӨВЛӨМЖ**

2019.04.08

Баянхонгор хот

Орон нутгийн хөгжлийн сангийн 2018 оны хөрөнгийн зарцуулалт, үр дүнд хийсэн аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн доорх албан тушаалтнуудад дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

**Нэг. Аймгийн ИТХ-ын дарга Ц.Отгонбаяр танаа**

1. Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.4 дэх заалтын дагуу ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэл, тайлагнал бүртгэлийн явцад ИТХ-ын дэргэдэх Хяналтын хорооны тавих хяналтыг сайжруулж, тайланг ИТХ-аар хэлэлцэж дүгнэлт өгч холбогдох шийдвэр гарган биелэлтийг тооцож байх.

**Хоёр. Аймгийн Засаг дарга Г.Батжаргал танаа**

1. Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр заасан төсөл арга хэмжээний зураг төсвийн үнийг ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлж, Төсвийн тухай хуулийн 60.3.1 дэх заалтыг зөрчин улсын төсвийн байгууллагын барилга, их засварын зураг төсвийн үнийг санхүүжүүлдэг явдлыг зогсоох.

2. Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрт орох хандив тусламжийн орлогыг бодитоор төлөвлөж байх.

3. Аймаг сумын ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд мэргэжлийн байгууллагаар захиалагчийн хяналтыг хийлгэж Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын хавсралт 4 маягыг бүрдүүлж журмын 4 дүгээр зүйлийн 4.12, 4.18 дахь заалтуудыг хэрэгжүүлж ажиллах

4. Ойжуулалт, ойн зурвас, ногоон байгууламж бий болгох, булаг шандын эхийг хашах зэрэг төсөл, арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэхдээ гэрээнд Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд, Сангийн сайдын 2013 оны хамтарсан тушаалаар батлагдсан “Ойжуулалт ойн арга хэмжээний ажлыг төлөвлөх, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын санд худалдан авах, өмчлүүлэх журам”-ыг мөрдөж, техникийн тодорхойлолтыг мэргэжлийн байгууллагаар хийлгэж тэдгээрийн оролцоо, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэн, төсөл хөтөлбөрийн байршил, цэг солбицлыг тодорхой тусгах.

**Гурав.** Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн дарга Д.Ихбаяр танаа

1. Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.3<sup>23</sup> дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах.

**Дөрөв.** Сумын ИТХ-ын дарга, Засаг дарга нарт

1. Сумын ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг журмын дагуу сонгон шалгаруулж, мэргэжлийн байгууллагаар захиалагчийн хяналтыг хийлгүүлж Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын хавсралт 4 маягтыг бүрдүүлж журмын 4 дүгээр 4.12, 4.18 дахь заалтуудыг хэрэгжүүлж ажиллах

2. ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлэхийг хориглосон төсөл, арга хэмжээг баталдаг явдлыг зогсоож, сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулахгүй байх.

3. Иргэдээс авсан саналын дагуу Төсвийн тухай хуулийн 58.4.8 дахь заалтын хүрээнд иргэдийн хувийн өмчлөлд засвар тохижилт хийх ажлыг хэрэгжүүлэхдээ иргэдийн оролцоог хангаж, гарах зардлын 50 хүртэл хувийг иргэдээс төвлөрүүлсэний дараа арга хэмжээг хэрэгжүүлж байх.

4. Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг иргэдэд хүртээмжтэй хүргэж иргэдийн идэвхи, оролцоог нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах.

5. ОНХС-ийн хөрөнгөөр малжуулах арга хэмжээнд зарцуулсан хөрөнгийн хэрэгжилтийг сумын ИТХ-р хэлэлцүүлж үр дүнг тооцож, үр ашгийг дээшлүүлэх талаар шийдвэр гаргуулж ажиллах.

6. Ойжуулалт, ойн зурвас, ногоон байгууламж бий болгох, булаг шандын эхийг хашах зэрэг төсөл, арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэхдээ гэрээнд Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд, Сангийн сайдын 2013 оны хамтарсан тушаалаар батлагдсан “Ойжуулалт ойн арга хэмжээний ажлыг төлөвлөх, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын санд худалдан авах, өмчлүүлэх журам”-ыг мөрдөж, техникийн тодорхойлолтыг мэргэжлийн байгууллагаар хийлгэж тэдгээрийн оролцоо, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэн, төсөл хөтөлбөрийн байршил, цэг солбицлыг тодорхой тусгах.

<sup>23</sup> 9.3.Аймаг, нийслэлийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь ОНХС-ийн хэрэгжилтийн тайланг сум, дүүрэг тус бүрээр хагас жил тутамд гарган, дүгнэлт өгч, цаашид даруй авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний саналыг боловсруулан аймаг, нийслэлийн Засаг даргад танилцуулж, холбогдох асуудлаар тодорхой шийдвэрийг гаргуулна.



Нийцлийн аудитаар тогтоосон акт, албан шаардлагыг хугацаанд нь биелүүлж, өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, гарсан үр дүнгийн талаар 2019 оны 09 дүгээр сарын 10-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт хариу ирүүлэх.